



ELC LLP ADVOCATES
ӨМГӨӨЛЛИЙН “ИЭлСи” ХХН

Floor 6, Palace of Democracy,
Genden Street 16, 1st khoroo,
Sukhbaatar District
Ulaanbaatar, Mongolia
Phone: 77118193; 77118194

Bayar Budragchaa,
Managing Partner
Mobile: 976 88105991
bayar@elclawoffice.mn;
Website: www.elclawoffice.mn
POBox – 371, Ulaanbaatar-14240

Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр 2
(АМЭБСХАХ-2)

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХИЙДЛИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Бүдрагчаагийн Баяр, Хуулийн зөвлөх (Техник, эдийн засгийн үндэслэл)

Өмгөөллийн ИЭлСи ХХН

Улаанбаатар хот

2020

ТОВЧИЛСОН ҮГ

АСИ	Адам Смит Интернэйшнл
АМЭБСХАХ-2	Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр 2
Зөвлөл	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
Зөвлөлийн дүрэм	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/46 тоот тушаал (Дүрэм аргачлал батлах тухай)-аар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм
АГХХЯ	Австралийн Гадаад хэрэг, Худалдааны Яам
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТЭЗҮ-ийн журам	Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 074 тоот тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах журам”
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
АМГТГ	Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Ажлын хэсэг	2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/251 тушаалаар байгуулагдсан ТЭЗҮ-ийн журмыг хянаж, шинэчлэн боловсруулах ажлын хэсэг

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ	1
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:	3
(i) Танилцуулга	3
(ii) Ажлын цар хүрээ	3
НЭГ. ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ	4
ХОЁР. МОНГОЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖ.....	6
2.1. Хуулиуд:	6
2.2. Журам, заавар:.....	6
ГУРАВ. НАРИЙВЧИЛСАН СУДАЛГАА	9
3.1. Зорилго, ашиглалт	9
3.2. Агуулга, шаардлага	12
3.3. Оролцогчид ба хянах процесс.....	13
ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ.....	18
ХАВСРАЛТ: ХУУЛИЙН ХИЙДЛИЙН СУДАЛГААНЫ ХҮСНЭГТ	20

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

(i) Танилцуулга

АМЭБСХАХ-2 хөтөлбөрийн ажлын нөхцөлөөс ишлэв:

Монгол Улсын Засгийн газар болон Австрали Улсын Засгийн газар эрдэс баялагт тулгуурласан тогтвортой өсөлтийг бий болгоход Монгол Улсад дэмжлэх үзүүлэх зорилгоор Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн эхний үе шат 2015-2019 онд амжилттай хэрэгжсэн ба хоёр дахь үе шат 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн өргөн цар хүрээ, оролцогчидтойгоор хэрэгжиж байна.

АМЭБСХАХ-2 -ийг Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлж, АСИ хэрэгжүүлж байгаа болно. Хөтөлбөрийг 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хэрэгжүүлнэ. АМЭБСХАХ-2 жилийн ажлын төлөвлөгөөнд “Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах журмыг” хянаж, шинэчлэхэд УУХҮЯ-нд дэмжлэг үзүүлэх ажил багтсан.

Журам нь 2012 оны “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах журам” юм.

(ii) Ажлын цар хүрээ

2019 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн Гэрээний дагуу Б.Баяр хуульчаар ахлуулсан Өмгөөллийн ИЭлСи ХХН нь одоо үйлчилж буй ТЭЗҮ-ийн Журмыг хянаж, Монголын хууль тогтоомжид хэрхэн нийцэж байгаа талаар хууль тогтоомжийн хийдлийн судалгаа хийх (болон бусад) үүрэг хүлээсэн.

Энэхүү хууль тогтоомжийн хийдлийн судалгаагаар техник, эдийн засгийн үнлэслэлийн зохицуулалт одоогийн хуулийн тогтолцоонд хэрхэн тусгагдсаныг судлаж, Монголын хүчин төгөлдөр зохицуулалт болон олон улсын сайн туршлага хооронд ямар зөрүүлэхийдэл байгааг тодорхойлж, зөвлөмж хүргүүлэхийг зорьсон.

НЭГ. ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Хууль зүйн үүднээс бид засаж, шинэчлэх шаардлагатай дараах хууль тогтоомжийн хийдлийг илрүүлсэн болно:

- Одоо үйлчилж буй ТЭЗҮ-ийн журам хууль зүйн хувьд хүчин төгөлдөр бус байна. Хэрвээ Ажлын хэсэг заавал дагаж мөрдөх хүчин чадал бүхий журмаар ТЭЗҮ боловсруулахтай холбоотой харилцааг зохицуулах хүсэлтэй бол Ашигт малтмалын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулж тухайн журмыг батлах тусгайлсан эрхийг УУХҮЯ-д олгосон заалтыг оруулах шаардлагатай. Энэ тохиолдолд журмыг боловсруулж, батлуулахад Захиргааны ерөнхий хуульд заасан (энэхүү тайлангийн 4 дүгээр бүлэгт дурдсан) журмыг баримтална. Үгүй бол стандарт, заавар кодекс зэрэг хуулийн заавал дагаж мөрдөх хүчин чадалгүй, сонгон хэрэглэх боломжтой бусад аргаар ТЭЗҮ-тэй холбоотой асуудлыг зохицуулж болно.
- ТЭЗҮ-ийн журам, Зөвлөлийн дүрэм болон Ашигт малтмалын тухай хууль нь хоорондоо давхардсан бөгөөд зөрчилдсөн заалтуудтай байгаа ба процедурын шинжтэй зохицуулалт нь системтэй биш, ойлгомжгүй, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёологдоогүй байна. Иймд ТЭЗҮ-ийн журмыг шинэчлэхээс гадна Зөвлөлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэж болно.
- Уул уурхайн салбарын ТЭЗҮ-ийг боловсруулах хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн асуудал тодорхойгүй байна. Хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл (Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн хүрээнд) олгох зохицуулалт бүхий БХБЯ-аас баталсан журамд 2018 оны 12 дугаар сард өөрчлөлт орсон ба энэхүү асуудлыг зохицуулаагүй үлдээсэн байна. Хэрвээ УУХҮЯ нь ТЭЗҮ боловсруулах аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд болох хүсэлтэй бол Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд (шаардлагатай бол Ашигт малтмалын тухай хуульд ч мөн адил) нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болно. Эсхүл бусад улстай адилаар хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авахыг шаардахгүйгээр ТЭЗҮ боловсруулах мэргэшсэн мэргэжилтэн байхыг шаардаж, тухайн мэргэжилтэн ёс зүйн дүрмийнхээ дагуу өөрийнхөө үйлдэл, үйл ажиллагаанд хариуцлага хүлээдэг байхаар зохицуулж болох юм.
- ТЭЗҮ-тэй холбоотой одоо үйлчилж буй Монгол Улсын зохицуулалт болон бусад улсын туршлагын гол зөрүү нь ТЭЗҮ гэх баримт бичгийн зорилго юу вэ гэдэгт байна. Монгол Улсад ТЭЗҮ-ийг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг хянах, шалгах, улсын хэмжээний судалгаа хийх болон эдийн засгийн дүн шинжилгээ хийх зэргээр зохицуулалтын зорилгоор ашиглаж байгаа бол барууны орнуудад зөвхөн бизнесийн зорилгоор буюу төслийн санхүүжүүлэгч, зээлдүүлэгч болон хөрөнгө оруулагч нар хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад зориулж боловсруулдаг байна. Иймд холбогдох журмыг

шинэчлэхдээ зорилгыг тодорхойлон, тухайн зорилгод нийцүүлэн зохицуулалтыг боловсруулах нь зүйтэй байна.

Дээрхээс гадна, ТЭЗҮ-тэй холбоотой асуудлыг бүхлээр нь бөгөөд бусад хууль тогтоомжтой уялдаатай байдлаар зохицуулах үүднээс журмыг шинэчлэхдээ 4-р бүлэг (Зөвлөмж)-т дурдсан асуудлуудыг харгалзан үзэх шаардлагатай.

ХОЁР. МОНГОЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

Монголд эрдэс баялгийн салбарын техник, эдийн засгийн үндэслэлийг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна:

2.1. Хуулиуд:

Ашигт малтмалын тухай хууль (2006):

Энэхүү хууль дахь ТЭЗҮ-тэй холбоотойгоор Зөвлөлийг байгуулах болох түүний чиг үүрэг (Хуулийн 10.1.9 дахь заалт), ТЭЗҮ-д уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, дэд бүтцийг хэрхэн бүрдүүлэх болон уурхайн нөхөн сэргээлт, хаалт зэрэгт шаардагдах хөрөнгийн талаар тодорхой тусгах (Хуулийн 27.1.12 дахь заалт), ТЭЗҮ-ийг ирүүлэх (Хуулийн 48.6.1 дахь заалт), ТЭЗҮ-ийг уурхай дээр байлгах (Хуулийн 35.3.2 дахь заалт) зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг болон ТЭЗҮ-ийн нууцлалыг хадгалах (Хуулийн 57.2 дахь хэсэг) талаарх ерөнхий зохицуулалтыг тусгасан байна.

Түүнчлэн энэхүү хуульд ТЭЗҮ-ийг болосвруулах эрх бүхий этгээд болон дүгнэлт гаргах мэргэшсэн мэргэжилтэн шинжээчийн чиг үүргийг тусгаж (Хуулийн 48.4, 48.6.1 ба 48.12 дахь хэсэг), тухайн шинжээчийг томилох, дүгнэлт гаргах хугацааг тодорхойлсон байна (Хуулийн 48.4 дахь хэсэг).

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012):

Энэ хуулийн дагуу төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл болон бусад баримт бичгийг бүрдүүлэн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ (Хуулийн 7.3 дахь хэсэг). Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг (бусад бичиг баримтын хамт) хавсаргах шаардлагатай.

Газрын хэвлийн тухай хууль (1988):

Энэхүү хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын зураг төслийг гагцхүү ашигт малтмалын нөөцийг нь баталж, ордыг үйлдвэрийн ашиглалтад зориулан шилжүүлж, ашиглах *техник-эдийн засгийн үндэслэлийг* нь баталсны дараа зохионо...” гэж заасан байна.

2.2. Журам, заавар:

Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах журам

Энэхүү журмыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 074 тоот тушаалаар баталсан.

Энэхүү ТЭЗҮ-ийн журмын зорилго нь ашигт малтмалын илрэлийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэх, хүлээн авахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохицуулахад оршино. Түүнчлэн төсөл хэрэгжүүлэгч болон төсөл боловсруулагчид тавигдах шаардлага, төсөл хэлэлцүүлэгч геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (АМГТГ), журмын хэрэгжилтэд хяналт тавих төрийн захиргааны төв байгууллагын хоорондын харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

ТЭЗҮ-ийг энэхүү ТЭЗҮ-ийн журамд дараах байдлаар тодорхойлжээ:

“Ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл гэж Улсын бүртгэлд бүртгэгдсэн нөөцөд тулгуурлан уул уурхайн (ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах) төслийг хэрэгжүүлэхэд чиглэсэн уулын үйлдвэрийн техник, технологийн сонголт, тооцоо, инженерийн шийдэл, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрх зүй, хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт, дэд бүтэц, хангамж, нийгэм, ахуй үйлчилгээ, эдийн засгийн үр ашгийн тооцоо болон холбогдох бусад хүчин зүйлийг нарийвчлан тооцсон зураг, тооцоо, тайлбар хэсгээс бүрдэх техникийн баримт бичгийг хэлнэ”.

Мөн энэхүү ТЭЗҮ-ийн журамд ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын урьдчилсан техник, эдийн засгийн үнэлгээ болон ашигт малтмалын ордыг ашиглах техникийн зураг төслийг тодорхойлсон бөгөөд журмын 3-6 дугаар хэсэгт тухайн бичиг баримтын агуулгыг жагсааж, тэдгээрт тавих шаардлагыг тусгасан байна.

Хэдийгээр журамд 4 төрлийн бичиг баримтыг зохицуулахаар заасан боловч сүүлийн хэсэг буюу 7 ба 8 дугаар хэсэг нь зөвхөн ТЭЗҮ-ийг боловсруулах, ашиглах, хүлээн авахад хамаарахаар байна.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм

Энэхүү дүрмийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/46 тоот тушаал (Дүрэм аргачлал батлах тухай)-ын хавсралтаар баталсан.

Энэхүү дүрмээр Зөвлөлийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, эрх үүрэг болон хурлын дэгийг тодорхойлсон байна. Тодруулбал дүрэм нь (i) Нийтлэг үндэслэл (ii) Зөвлөлийн эрх, үүрэг (iii) Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт (iv) Зөвлөлийн салбар хуралдааны хэлэлцэх асуудал (v) Хуралдааны дэг (vi) Шинжээчийн эрх, үүрэг болон (vii) Хариуцлага гэсэн нь 7 бүлэгтэй.

2.3. Бусад журам, заавар

ТЭЗҮ-ийн талаар зохицуулалт агуулсан журам, зааварт дараах орж байна:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/20 тоот тушаалаар баталсан “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”;
- АМГТГ-ын даргын 2016 оны а/22 тоот тушаалаар баталсан “Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ хүлээн авах заавар”;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/19 тоот тушаалаар баталсан “Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам”;
- АМГТГ-ын даргын 2016 оны а/30 тоот тушаалаар баталсан “Геологийн тайлан хүлээн авах, бүртгэх, хадгалах, ашиглах журам” зэрэг.

2.4. Журмын хүчин төгөлдөр байдал:

Захиргааны байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн бичиг баримтыг “**захиргааны хэм хэмжээний акт**” гэх бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 59.1 дүгээр хэсэгт заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг (i) гадагш чиглэсэн (ii) үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй, (iii) хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэр гэж тодорхойлсон.

Захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу ХЗДХЯ-нд хүргүүлэн бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д бүрэн эхээр нь нийтлүүлснээр хүчин төгөлдөр болно. Ийнхүү бүртгүүлэн нийтлүүлээгүй тохиолдолд тухайн захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй бөгөөд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй.

ТЭЗҮ-ийн харилцааг зохицуулж буй гол бичиг баримт болох “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах журам”-ыг нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан. Өөрөөр хэлбэл энэхүү журмыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон ТЭЗҮ-ийг боловсруулах, хүлээн авах ажиллагаанд оролцогч бусад этгээд дагаж мөрдөх шаардлагатай тул ТЭЗҮ-ийн журмыг баталсан шийдвэр нь *гадагш чиглэсэн* байна.

Түүнчлэн энэхүү журам нь бүх уул уурхайн төслийн ТЭЗҮ-ийг бэлдэхэд хамаарч байгаа нь тухайн журмын *үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй* байгааг харуулж байна.

Ашигт малтмалын тухай хуульд аливаа захиргааны байгууллагаас ТЭЗҮ-тэй холбоотой асуудлыг нийтээр дагаж мөрдүүлэхээр зохицуулах тусгайлсан эрх олгосон заалт байхгүй тул энэхүү ТЭЗҮ-ийг журам захиргааны хэм хэмжээний актын шаардлагыг хангахгүй байна. Түүнчлэн ХЗДХЯ-д энэхүү журмыг захиргааны хэм хэмжээний акт хэмээн бүртгүүлээгүй байна.

Үүний үр дагаварт энэхүү Журам эрх зүйн үйлчлэлгүй байгаа ба тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд дагаж мөрдөх үүрэг үүсгэхгүй байна.

Харин Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журмыг Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалтаар УУХҮЯ-д эрх олгосны дагуу захиргааны хэм хэмжээний актаар зохих ёсоор бүртгүүлсэн байна.

ГУРАВ. НАРИЙВЧИЛСАН СУДАЛГАА

Энэ бүлэгт ТЭЗҮ-тэй холбоотой Монголын хууль тогтоомжийг нарийвчлан судлаж, олон улсын практиктай харьцуулан хийдэл, зөрүү байгаа эсэхийг тогтооно. Олон улсын туршлагыг бусад улс дахь ТЭЗҮ-ийн ашиглалт, зорилго, шаардлага болон агуулга, түүнийг хянах процесс, ТЭЗҮ боловсруулагчийн зохицуулалт зэргийн талаарх мэдээлэл бүхий Стив Геммелийн Ажлын хэсэгт зориулан гаргасан ТЭЗҮ-ийн талаарх тайланд (цаашид “Геммелийн тайлан” гэх) үндэслэсэн болно.

3.1. Зорилго, ашиглалт

Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6.1 дэх заалтын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар хийлгэж, ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

Ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлдээ тухайн уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, дэд бүтцийг хэрхэн бүрдүүлэх болон уурхайн нөхөн сэргээлт, хаалт зэрэгт шаардагдах хөрөнгийн талаар тодорхой тусгасан байна (Ашигт малтмалын тухай хуулийн 27 дугаар зүйл).

Техник, эдийн засгийн үндэслэлийг ТЭЗҮ-ийн журамд Улсын бүртгэлд бүртгэгдсэн нөөцөд тулгуурлан уул уурхайн (ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах) төслийг хэрэгжүүлэхэд чиглэсэн уулын үйлдвэрийн техник, технологийн сонголт, тооцоо, инженерийн шийдэл, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрх зүй, хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт, дэд бүтэц, хангамж, нийгэм, ахуй үйлчилгээ, эдийн засгийн үр ашгийн тооцоо болон холбогдох бусад хүчин зүйлийг нарийвчлан тооцсон зураг, тооцоо, тайлбар хэсгээс бүрдэх техникийн баримт бичгийг хэлнэ гэж тодорхойлсон.

Ашиглалт:

ТЭЗҮ-ийн журамд зааснаар түүнийг гурван хувь үйлдсэн байх бөгөөд (i) төсөл хэрэгжүүлэгч, (ii) Ашигт малтмалын газрын Геологи судалгааны хэлтсийн архив болон (iii) Уул уурхай, судалгааны хэлтэс, нүүрсний төсөл бол Нүүрс, судалгааны хэлтэст тус тус нэг хувийг хадгална. Уул уурхай, судалгааны хэлтэс эсхүл Нүүрс, судалгааны хэлтэс хүлээн авсан техник, эдийн засгийн үндэслэлийг ордын ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор ашиглана гэж заасан. Ашигт малтмалын газрын даргын 2016 оны А/30 тушаалаар батлагдсан Геологийн тайлан

хүлээн авах, бүртгэх, хадгалах, ашиглах журамд ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ-г захиалж хийлгэсэн аж ахуйн нэгж нь Ашигт малтмалын газрын Геологийн төв архивт нэг хувь ирүүлэх бөгөөд нөгөө хувийг Уул уурхайн хэлтэст бусад баримт бичгүүдийн хамт хүлээлгэн өгнө гэж заасан.

Ашигт малтмалын газрын нэр Ашигт малтмал газрын тосны газар гэсэн нэртэй болж өөрчлөгдсөн бөгөөд хэлтэсийн нэр мөн өөрчлөгдсөн байна. Иймд журамд буюу захиргааны хэм хэмжээ тогтоосон актад эрх бүхий байгуулага, хэлтэсийн оноосон нэрийг дурдах нь зохимжгүй бөгөөд үйл ажиллагааны чиг үүргээр тухайн байгууллагыг дурдах нь зүйтэй байна.

Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журмыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/20 тоот тушаалаар баталсан ба энэхүү журмын 8.2 дахь хэсэгт “ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь улсын бүртгэлд бүртгэгдсэн нөөцөд тулгуурлан уул уурхайн (ашигт малтмал олборлох, баяжуулах) төслийг хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан байна” гэж заасан. Түүнчлэн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсаны дагуу уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжийг барьж байгуулах... (8.6 дахь хэсэг) ба уулын ажлын төлөвлөгөө, түүний биелэлтийн тайланг тухайн ордыг ашиглах болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл дээр тулгуурлан хийнэ... (9.5 дахь хэсэг) гэж заасан.

АМГТГ-ын даргын түр орлон гүйцэтгэгчийн 2016 оны а/22 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ хүлээн авах зааврын дагуу дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд, уулын ажлын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн төлөвлөгөөг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлана... гэж заасан.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмал ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг уурхай дээр байлгах үүрэгтэй (Ашигт малтмалын тухай хуулийн 35.3.2 дахь заалт бөгөөд техник, эдийн засгийн үндэслэлийн хэрэгжилтийг хангахдаа жил бүрийн тайлан, уулын ажлын төлөвлөгөөгөөр баталгаажуулах ба хянах ажлыг төрийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага хэрэгжүүлнэ (ТЭЗҮ-ийн журмын 7.4 дэх хэсэг).

Дээрх заалтуудаас харахад ашигт малтмалын ордыг ашиглахад тусгай зөвшөөрөл эзэмшигч ТЭЗҮ-тэй байх шаардлагатай бөгөөд жил бүрийн уулын ажлын төлөвлөгөө, тайланг түүнд үндэслэн гаргадаг байна. Түүнчлэн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавихад ТЭЗҮ ашиглаж, мэргэжлийн хяналтын байгууллага ТЭЗҮ болон түүнийг үндэслэн хийсэн бусад бичиг баримт тулгуурлан хяналт, шалгалт хийхээр байна. Мөн ТЭЗҮ-ийн нэг хувийг АМГТГ-ын судалгааны хэлтэст хүргүүлж, холбогдох судалгаа дүгнэлт хийхэд ашигладаг байна.

Хэдийгээр Зөвлөлөөр хэлэлцсэний дараа техник, эдийн засгийн үндэслэлийг төрийн байгууллага “хүлээн авна” гэсэн байгаа ч хэд хэдэн эрх зүйн бичиг баримтад “батлуулна” гэж тусгасныг анхаарах хэрэгтэй.

Нэмэлт, өөрчлөлт:

Төсөл хэрэгжүүлэгч нь дараах тохиолдолд ТЭЗҮ-ийг тодотгох, шинэчлэх буюу шинээр боловсруулах үүрэгтэй:

- Уул уурхайн төсөлд хүчин чадал, техник, технологийн өөрчлөлт орсон,
- уг техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулснаас хойш ашиглалт явуулалгүй 3-аас дээш жилийн хугацаа өнгөрсөн,
- ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд болон
- тухайн техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсанаас хойш 5 жил тутамд.

Түүнчлэн ашиглалтын явцад техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан захын агуулга, кондици, нөөц зэрэг голлох үзүүлэлтүүдэд бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ ханшийн хэлбэлзэл, үйлдвэрлэлийн зардлын өөрчлөлт зэргээс шалтгаалан гарах бага хэмжээний эдийн засгийн өөрчлөлтийг төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн эцэст шинэчлэн тогтоож, дараа жилийн уулын ажлын төлөвлөгөөнд тусган Уул уурхай, судалгааны хэлтэс эсхүл Нүүрс, судалгааны хэлтэст мэдэгдэж байх үүрэгтэй. Энд дурдсан үзүүлэлтэд гарсан өөрчлөлтөөс шалтгаалан нөөц нэмэгдэж, хасагдвал Уул уурхай, судалгааны хэлтэс эсхүл Нүүрс, судалгаа хэлтсийн саналаар нөөцийн хөдөлгөөнд өөрчлөлт оруулж нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд шинэчлэн бүртгүүлэх үүрэгтэй байна (ТЭЗҮ-ийн журмын 7.5 ба 7.6 дахь хэсэг).

Хэдий хуулиар үүрэг оногдуулаагүй байгаа боловч ТЭЗҮ-ийн журмаар тусгай зөвшөөрөл эзэмшигч буюу төсөл хэрэгжүүлэгчийг ТЭЗҮ-ийг тодотгох, шинэчлэх буюу шинээр боловсруулахыг шаардсан байна. Журамд хуульд зааснаас давсан зохицуулалт оруулсан байна.

Нууцлал:

Ашигт малтмалын тухай хуулийн 57.2 дахь хэсэгт заасны дагуу төрийн захиргааны байгууллага техник, эдийн засгийн үндэслэлийг түүний хүсэлтээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд нууцад хамааруулна. Төрийн захиргааны байгууллага мэдээ, тайланг хүлээн авахдаа нууц хадгалах талаар гэрээ байгуулж болно.

Хувийн хөрөнгөөр хайгуул хийгдэж нөөц нь тогтоогдсон ордын тайлан, техник эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг нийтийн хэрэгцээнд ашиглах тохиолдолд холбогдох байгууллага болон тухайн тайланг хийж гүйцэтгэсэн хуулийн этгээдээс зөвшөөрөл авна гэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/19 тоот

тушаалаар батлагдсан Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журамд заасан.

Байгаль орчин, ашигт малтмалын чиглэлийн 30 хуулийн хийдэл, зөрчил, давхардлыг тогтоох, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах судалгааны ажлын тайланд¹ дурдсанаар энэхүү нууцлалын зохицуулалт Байгууллагын нууцын тухай хуультай зөрчилдсөн байна гэж дүгнэсэн. Байгууллагын нууцын тухай хуульд тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээллийг нууцалж болохгүй гэж заасан. Гэвч ТЭЗҮ-д зөвхөн энэ мэдээллээс гадна байгууллагын санхүүгийн мэдээлэл зэрэг задруулахад анхаарах мэдээлэл байдгийг харгалзаж үзэх шаардлагатай.

Геммелийн тайланд дурдсанаар ТЭЗҮ-ийн зорилго нь уул уурхайн төсөл болон түүнд хамаарах байгаль орчны талаарх тоон болон чанарын үзүүлэлтийг харуулах бөгөөд барууны орнуудад төслийн спонсор, хөрөнгө оруулагч нар болон санхүүжүүлэгчид (“Сонирхогч талууд”) итгэлтэйгээр шийдвэр гаргахад зөвхөн зориулагддаг байна. Үүнээс үүдэн ТЭЗҮ-ийн агуулга, нөхцөлд сонирхогч талуудын шаардлага ач холбогдолтой байдаг. Төрийн байгууллагууд ТЭЗҮ-ийг зохицуулалтын зорилгоор ашиглах нь ховор бөгөөд (жишээ нь Австралын Викториа муж) ТЭЗҮ-ийн оронд бусад нотлох баримтуудыг хүлээн зөвшөөрдөг байна.

Монголын хууль тогтоомжид ТЭЗҮ-ийг илүү зохицуулалтын зорилгоор тусгасан байдаг бол бусад улсад төслийн талаар стратегийн шийдвэр гаргахад хөрөнгө оруулагч, сонирхогч талуудад зориулсан бичиг баримт гэж үздэг байна.

Нууцлалын хувьд хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд (хувьцаат компани) нийтэд тайлагнах үүргийг зарим улс шаарддаг байна.

3.2. Агуулга, шаардлага

ТЭЗҮ-ийн журмын 3-р бүлэг (Ашигт малтмалын баялагт урьдчилсан үнэлгээг боловсруулахад тавигдах шаардлага), 4-р бүлэг (Ашигт малтмалын ордын урьдчилсан техник, эдийн засгийн үнэлгээг боловсруулахад тавигдах шаардлага), 5-р бүлэг (Ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад тавигдах шаардлага) болон 6-р бүлэг (Ашигт малтмалын ордыг ашиглах техникийн зураг төслийг боловсруулахад тавигдах шаардлага)-т тухайн бичиг баримтуудад тусгах агуулга, шаардлагыг дурдсан байна.

Бусад улсын хувьд тухайн бичиг баримтыг ашиглагч нар буюу спонсрууд, хөрөнгө оруулагчид, зээлдэгч нарын шаардлагаас үүдэн ТЭЗҮ-д тавигдах шаардлага тодорхойлогдох бөгөөд тэдгээр нь төслийн ашиг, эрсдэлд ихэвчлэн анхаардаг. Хөрөнгө оруулалт татах зориулалтаар хийгдсэн ТЭЗҮ-үүд төслийн

¹ УУХҮЯ, ХЗДХЯ, БОАЖЯ хамтран Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах” төслийн дэмжлэгтэйгээр 2017 онд хийсэн судалгаа.

үзүүлэлтээс хамаарахгүйгээр ижил бүрэлдэхүүн хэсгүүдтэй байдаг. Мэдээж үйл ажиллагааны онцлогоос хамааран зарим хэсгийг хасах, бууруулах тохиолдол бий. Зарим улсын хувьд ТЭЗҮ-ийг зохицуулахаас илүү (үндсэн стандартыг тогтоож) нийтэд тайлагнах кодексийн дагуу ТЭЗҮ-ийг олон нийтэд тайлагнахыг шаардах замаар зохицуулдаг байна².

Энэхүү тайлангаар хуулийн хийдлийг тогтоох зорилготой тул Монгол болон бусад улсын ТЭЗҮ-ийн агуулгад тавигдах шаардлагын ялгаатай байдлын талаарх судалгааг оруулаагүй болно. Гэвч Монголын хууль тогтоомжид төслийн төрөл, онцлогоос шалтгаалсан өөр өөр шаардлага байхгүй ба төслөөс хамааран зарим шаардлагыг хасах боломжтой эсэхийг дурдаагүй байгааг анхаарах нь зүйтэй.

3.3. Оролцогчид ба хянах процесс

Оролцогчид:

Монголын хууль тогтоомжийн дагуу техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, хянах, хүлээн авахад дараах оролцогчид дор дурдсан чиг үүрэгтэй оролцдог байна:

Төсөл хэрэгжүүлэгч: ТЭЗҮ-ийн журамд тодорхойлсноор төсөл хэрэгжүүлэгч гэж Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч эсхүл ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрлэл эрхлэх хуулийн этгээдийг хэлнэ.

Төсөл боловсруулагч: Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6.1 дэх заалт ба ба 48.12 дахь хэсэгт заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, тэдгээрт хийх хөндлөнгийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг мэргэшсэн мэргэжилтэн, эрх бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ. ТЭЗҮ-ийн журамд төсөл боловсруулагчийг Геологи, уул уурхайн эрдэм шинжилгээ, судалгаа, зураг төслийн эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж байх ба энэ чиглэлийн эрх бүхий Монгол Улсын зөвлөх инженерээр зөвлүүлсэн хуулийн этгээдийг хэлнэ гэж тодорхойлсон.

Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч гэж үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, геологи, уул уурхайн салбарын төрийн бус байгууллагаас эрх олгогдсон иргэнийг хэлнэ (Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.26 дахь заалт ба Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам).

Одоогоор Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 1 дүгээр сарын 19-ны өдрийн 11 тоот тушаалаар баталсан журмын дагуу ТЭЗҮ боловсруулах хуулийн этгээд Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ-аас тусгай зөвшөөрөл

² Стив Геммелийн Ажлын хэрэгт зориулан гаргасан тайлангаас

(барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн хүрээнд) авах шаардлагатай.

Гэвч Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 217 тоот тушаалаар тухайн журам хүчин төгөлдөр бус болсон байх бөгөөд шинээр баталсан журамд ТЭЗҮ боловсруулах хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох асуудлыг тусгаагүй байна. Иймд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудал зохицуулагдаж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Геммелийн Ажлын хэсэгт зориулсан тайланд дурдсанаар ихэнх улсуудад ТЭЗҮ-ийг төслийн спонсрууд, эсхүл хараат бус мэргэжилтэн, уул уурхайн төслийн зөвлөх болон инженерийн компаниуд боловсруулдаг байна. Тусгайлсан чадвар шаарддаг тул бизнесийн ихэнх ТЭЗҮ-ийг бие даасан мэргэшсэн компани хийдэг. Тухайн компаниуд хангалттай тооны, зохих эрх авсан, ур чадвартай бөгөөд туршлагатай ажилтнуудтай ба тэдгээрээр ТЭЗҮ-ийг боловсруулуулдаг. Компаниудын энэхүү үйл ажиллагааг ерөнхийдөө зохицуулдаггүй боловч тэд сайн дураараа олон улсын стандартын дагуу гэрчлэгддэг байна. Хувь хүн боловсруулах тохиолдолд тухайн хүн магадлан итгэмжлэгдсэн байдаг. Тэд зохих дээд боловсрол эзэмшсэн бөгөөд холбогдох мэргэжлийн байгууллагад бүртгүүлсэн гишүүн байдаг байна. Мэргэжлийн байгууллага нь гишүүддээ заавал дагаж мөрдүүлдэг ёс зүйн дүрэмтэй бөгөөд гишүүддээ сахилгын хариуцлага тооцох эрх хэмжээтэй. Зарим улсад инженерийн мэргэжилтэй ТЭЗҮ боловсруулагчид нь зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барих, тайлагнах үйл ажиллагаа эрхлэхээс өмнө “мэргэжлийн инженер” (эсхүл төстэй нэршил)-ээр төрийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй байдаг. Энэхүү нэрийг шалгалт өгөх, эсхүл тухайн этгээдийн мэргэжлийн зэрэг, туршлагыг хянасны үндсэн дээр олгодог байна. Улс өөрөө, эсхүл төрөөс томилсон зөвлөл, мэргэжлийн байгууллагад эрхээ шилжүүлэх замаар бүртгэл хийж болдог.

Мэргэшсэн мэргэжилтэнтэй холбоотой практик нь Монголын зохицуулалттай адил байгаа боловч хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох асуудал ялгаатай байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны холбогдох төв байгууллага олгоно, мөн тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг тус тусын хуулиар зохицуулна гэж заасан.

Зам, тээврийн хөгжлийн яам зэрэг зарим төрийн захиргааны төв байгууллага өөрийн салбарын ТЭЗҮ-ийг боловсруулах тусгай зөвшөөрлийг салбарын хууль тогтоомжоор зохицуулдаг ба Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль дахь тусгай зөвшөөрлийн жагсаалтад оруулсан байна.

Хэрвээ УУХҮЯ хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох эрх хэмжээтэй байх хүсэлтэй бол Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт

өөрчлөлт оруулан тусгай зөвшөөрлийг нэмж, Ашигт малтмалын хуульд нарийвчилсан журмыг тусгах шаардлагатай болно.

Эсхүл бусад улсын жишгээр хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авахыг шаардахгүй бөгөөд ТЭЗҮ-ийг боловсруулах мэргэшсэн мэргэжилтэнтэй байж, тухайн мэргэжилтэн ёс зүйн дүрмийн дагуу өөрийн үйлдэл, үйл ажиллагаанд хариуцлага хүлээх байдлаар зохицуулж болох юм.

Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага: ТЭЗҮ-ийн журамд АМГТГ-ыг төсөл хэлэлцүүлэгч гэж дурдсан байх ба Зөвлөлийн дүрмийн дагуу ТЭЗҮ-ийг АМГТГ-ын тухайн асуудал хариуцсан нэгж хянаж, санал дүгнэлтээ өгсний үндсэн дээр Зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүргүүлнэ гэж заасан.

Шинжээч: ТЭЗҮ-ийн журамд шинжээчийг геологи, уул уурхайн мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай инженер, салбарын доктор, профессор цолтон, тухайн мэргэжлээр мэргэшсэн болон Монгол Улсын зөвлөх инженерийг хэлнэ гэж тодорхойлсон.

Ордыг ашиглах, баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг АМГТС-аас зөвлөлд хүргүүлсний дараа зөвлөлийн дарга тухайн ТЭЗҮ-д шүүмж, мэргэжлийн дүгнэлт гаргах шинжээч болон шинжээчдийн хэсгийг тухайн асуудал хариуцсан салбар хуралдааны даргын саналыг үндэслэн томилно (Зөвлөлийн дүрэм).

Шинжээч нь ТЭЗҮ-д хийсэн өөрийн шүүмж, дүгнэлтийн үнэн бодит байдлыг хариуцна. Шинжээч нь орд ашиглах болон баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г боловсруулсан аж ахуйн нэгжийн мэргэжлийн ур чадвар, гүйцэтгэлийн чанарын талаар үнэлэлт, дүгнэлт өгөх, хариуцлагын талаар Зөвлөлд санал оруулах эрхтэй (Зөвлөлийн дүрэм).

Шинжээчийн чиг үүрэг, эрх үүрэг болон урамшууллын асуудлыг ТЭЗҮ-ийн журам болон Зөвлөлийн дүрэмд нарийвчлан тусгасан байх боловч зарим заалтууд давхардсан бөгөөд хоорондоо зөрчилдсөн байна.

Бусад улсын хувьд ТЭЗҮ-ийг хянах процесс нь тайланг боловсруулсан этгээдээс болон хэнд зориулснаас шалтгаалаад өөр өөр байдаг. Төслийн спонсруудын хариуцан хийлгэсэн ТЭЗҮ-ийг ихэвчлэн (гэхдээ дандаа биш) хараат бус/бие даасан шинжээчээр хянуулдаг. Шинжээч нэр хүнд бүхий зөвлөх фирмээс томилсон хувь хүн эсхүл баг байдаг байна³.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл: Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалтын дагуу УУХҮЯ нь ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэшсэн мэргэжилтнээс бүрдсэн гишүүдтэй эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний дүрэм, шинжээчийн ажлын хөлс тооцох аргачлалыг батлах бүрэн эрхийг эдэлнэ.

³ Стив Геммелийн Ажлын хэсэгт зориулсан тайлангаас

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, хуулийн этгээдээс ашигт малтмалын ордыг ашиглах, баяжуулах холбогдох заавар, журам, шаардлагад нийцүүлэн боловсруулж, шинжээчийн дүгнэлт гаргуулсан бол төрийн захиргааны байгууллагын тухайн асуудал хариуцсан нэгжээр хянуулж, хэлэлцүүлэх тухай санал авсны үндсэн дээр Зөвлөлийн холбогдох салбар хуралдаанаар хэлэлцэн зөвлөмж, дүгнэлт гаргана (Зөвлөлийн дүрэм).

Зөвлөл нь хэлэлцэх асуудлын онцлогтой уялдсан 4 салбар хуралдаантай бөгөөд ашигт малтмалын ордыг ашиглах ТЭЗҮ, газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний асуудал хэлэлцэх Зөвлөлийн салбар хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ:

1. Ашигт малтмалын орд ашиглах болон баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ;
2. Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө;
3. Уул уурхайн үйлдвэрлэлийн техник, технологийг боловсронгуй болгох, ашигт малтмалыг олборлон ашиглах явцад гарах хаягдлыг багасгах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэгт чиглэсэн судалгаа;
4. Уул уурхайн үйлдвэрлэлийн төслийн ТЭЗҮ-д тавигдах шаардлага, хүлээн авах заавар.

Дээрх салбар хуралдаанаар ашигт малтмалын ордыг ашиглах, баяжуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэхдээ Зөвлөлийн дүрмийн 2.1.2-т заасан (ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх асуудлаарх) зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн оновчтой арга аргачлал, техник технологийн шийдлээр, эдийн засгийн судалгаа, шинжилгээний үндэслэлтэйгээр боловсруулсан эсэхийг шинжээчийн дүгнэлт гаргуулсны үндсэн дээр хэлэлцэн тэмдэглэл хөтөлж, ТЭЗҮ-г хүлээж авах эсэх тухай дүгнэлт, зөвлөмж гаргана (Зөвлөлийн дүрэм).

Зөвлөлийн хурлын дэг, дарааллыг Зөвлөлийн дүрмээр зохицуулсан байна. ТЭЗҮ-ийн журмын 8 дугаар бүлэг дэх процедурын заалт Зөвлөлийн дүрэмтэй зөрчилдсөн байна.

Төрийн захиргааны төв байгууллага: ТЭЗҮ-ийн журамд УУХҮЯ буюу төрийн захиргааны төв байгууллага нь ТЭЗҮ-ийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй хэмээн тусгагдсан байна.

Хугацаа:

Хугацааны хувьд Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэгт төрийн захиргааны байгууллага буюу АМГТГ нь техник-эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс мэргэшсэн мэргэжилтнийг шинжээчээр 30 хоногт багтаан томилуулж, 90 хоногт багтаан хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсны үндсэн дээр техник, эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана гэж заасан.

ТЭЗҮ-ийн журамд Зөвлөлийн хурлыг сар болгоны эхний болон гуравдахь долоо хоног бүрийн пүрэв гаригт тогтмол хуралдуулах ба тухайн хурлыг ашигт малтмалаар нь төрөлжүүлэх хэлбэрээр зохион байгуулна, шаардлагатай тохиолдолд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн даргын шийдвэрээр тухайн өдрийг хүлээхгүйгээр хурлыг зарлаж болно гэж заасан боловч энэхүү хугацаа заасан зохицуулалт нь практикт зохих ёсоор хэрэгждэггүй.

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ

Журмын хүчин төгөлдөр байдал

Ашигт малтмалын тухай хуульд техник, эдийн засгийн үндэслэлийн чанар, түүнд тавих шаардлагатай холбоотой нарийвчилсан зохицуулалт байхгүй тул хууль тогтоомжид нийцсэн журам гаргах замаар ТЭЗҮ-ийн асуудлыг зохицуулах уу, эсхүл энэхүү асуудлыг заавал дагаж мөрдөх шаардлагагүй, сонгох боломжтой стандарт, заавар, кодекс зэргээр зохицуулах уу гэдгийг шийдвэрлэх шаардлагатай.

Тухайлсан журам гаргах тохиолдолд энэхүү тайланд дурдсаны дагуу тухайн журам нь хүчин төгөлдөр үйлчлэхийн тулд захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлагыг хангасан байх ёстой. Үүний тулд дараах арга хэмжээг авна:

- (i) Ашигт малтмалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, УУХҮЯ-д ТЭЗҮ-тэй холбоотой журам батлах тусгайлсан эрх олгосон заалт оруулах;
- (ii) Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлагыг хангах;
- (iii) Захиргааны хэм хэмжээний акт боловсруулах Захиргааны ерөнхий хуульд заасан журмыг дагаж мөрдөх; мөн
- (iv) ХЗДХЯ-д бүртгүүлэх.

(i) Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах:

2015 оны Хууль тогтоомжийн тухай хуульд заасан процессыг даган хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд дараах байдлаар товч дурдлаа:



(ii) Захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлага

Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу дараах шаардлагыг хангасан байна

- Монгол Улсын Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль болон бусад хуульд нийцсэн байх;
- тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх;
- тэмдэглэх хэсэгт үндэслэл болгож байгаа хуулийн заалтыг заасан байх;
- шийдвэрийн заалт хоорондоо болон эрх бүхий бусад этгээдийн гаргасан шийдвэрийн заалттай зөрчилдөхгүй байх;
- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэх;
- хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх;
- тухайн шийдвэрээр урьд нь гарсан шийдвэрийг хүчингүй болсонд тооцож байгаа, эсхүл түүнд өөрчлөлт оруулж байгаа бол энэ тухай заалтыг тусгасан байх;
- бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийгдсэн байх;
- баталсан байгууллага, албан тушаалтны болон захиргааны хэм хэмжээний актын нэр, он, сар, өдөр, дугаарыг тодорхой заасан байх;
- хуульд заасан бусад шаардлага (журмын төсөлд санал авах зэрэг).

(iii) Захиргааны хэм хэмжээний актын төслийг бэлтгэх, гаргах

Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх ажиллагааг тухайн актыг гаргах эрх бүхий захиргааны байгууллага зохион байгуулах ба зохицуулах харилцаа нь бусад захиргааны байгууллагын чиг үүрэгт давхар хамаарч байгаа бол тухайн захиргааны байгууллагаас албан ёсоор санал авна. Хэрэв ийнхүү саналыг аваагүй бол үндэслэл, шаардлагыг тайлбарлан хүргүүлнэ. Захиргааны хэм хэмжээний актыг боловсруулахдаа Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.6 дахь хэсэгт заасан аргачлалыг баримтлан дараах нөхцөл байдлыг тусгасан нөлөөлийн шинжилгээ хийнэ:

- акт гаргах үндэслэл, шаардлага, зорилт;
- тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ;
- акт гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлгийг тодорхойлох;
- хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх;
- тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх;
- актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн

тооцоо.

Мөн танилцуулга бэлдэнэ. Нөлөөллийн шинжилгээ гэж тухайн захиргааны хэм хэмжээний актын эдийн засаг, нийгмийн амьдралд үзүүлэх нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан судалж, тооцоолох цогц үйл ажиллагааг ойлгоно. Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлалыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Захиргааны хэм хэмжээний актын төслийг тухайн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж санал авах ба нийтийн ашиг сонирхол, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын төсөлд нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцох боломжоор хангах бөгөөд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг заавал хийнэ. Түүнчлэн дараах хүрээнд хэлэлцүүлэг хийж болно:

- эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд;
- эрдэмтэн, судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд;
- тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд;
- тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд.

Хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр зохион байгуулж болно:

- уулзалт, ярилцлага;
- өдөр тутмын сонин хэвлэлд төслийг нийтэлж санал авах;
- цахим хуудас, харилцаа холбооны хэрэгслээр санал авах;
- бусад.

Хэлэлцүүлгийн явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтөлж, гарсан саналыг захиргааны хэм хэмжээний актын төсөлд хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэнэ.

Захиргааны байгууллага захиргааны хэм хэмжээний актын төслийг нөлөөллийн шинжилгээний танилцуулга болон хэлэлцүүлгийн мэдээллийн хамт өөрийн байгууллагын хууль зүйн асуудал хариуцсан нэгж /газар, хэлтэс/, мэргэжилтнээр хянуулна.

(iv) ХЗДХЯ-д бүртгүүлэх

Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиргааны хэм хэмжээний актыг бүртгэхдээ Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

Журмыг шинэчлэх

Журмын төслийг шинэчлэн боловсруулах тохиолдолд дараах асуудлуудыг харгалзан үзэх шаардлагатай байна. Үүнд:

- ТЭЗҮ-ийн журамд 4 бичиг баримт буюу ашигт малтмалын баялагт урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын урьдчилсан техник, эдийн засгийн үнэлгээ,

- ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл болон ашигт малтмалын ордыг ашиглах техникийн зураг төслийг зохицуулахаар тусгасан боловч хадгалах, ашиглах, шинэчлэх болон хүлээн авах журам зөвхөн ТЭЗҮ-д хамааралтай байна. Журмыг шинэчлэхдээ эдгээр процедурын зохицуулалт бусад баримт бичгүүдэд хамаарах эсэхийг тодорхой болгох;
- Төслийн онцлогоос хамаараад тавигдах шаардлагууд өөр өөр байх эсэх, зарим шаардлагыг хасаж болох эсэхийг тодорхойлох. Мөн үнэн зөв агуулгатай байх үүднээс мэдээллийг хэр нарийвчлалтай гаргах талаарх шаардлагыг тусгах эсэхийг тодорхойлох;
 - ТЭЗҮ боловсруулагч этгээдэд тавигдах шаардлага болон хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох асуудлыг тодорхой болгох, хэрэв УУХҮЯ-аас олгох бол холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - Журмыг шинэчлэхдээ хуульд зааснаас илүү үүрэг оролцогчдод оногдуулсан заалт оруулахгүй байхад анхаарах;
 - Эрх бүхий төрийн байгууллага, хэлтсийн нэрний оронд тухайн байгууллага, хэлтсийг чиг үүргийг тусган дурдаж өгөх;
 - Байгаль орчин, ашигт малтмалын чиглэлийн 30 хуулийн хийдэл, зөрчил, давхардлыг тогтоох, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах судалгааны ажлын тайланд дурдсаныг харгалзан ТЭЗҮ-ийн нууцлалтай холбоотой заалтыг өөрчлөх;
 - Зөвлөлийн дүрмийг мөн хянаж, давхцал, зөрчил үүссэн тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах; болон
 - ТЭЗҮ-ийг хүргүүлэх, хянах, хүлээн авах (эсхүл батлах) хугацааг бодитой хэрэгжихүйц байдлаар тодорхойлж өгөх.

ХАВСРАЛТ: ХУУЛИЙН ХИЙДЛИЙН СУДАЛГААНЫ ХҮСНЭГТ

#	Асуудал	Зохицуулалт	Хийдэл, давхардал, зөрчил	Зөвлөмж
1	Хуулийн хүчин төгөлдөр байдал	074 тушаалаар батлагдсан журам	Эрх зүйн үйлчлэл үүсгэхгүй бичиг баримт	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулан, захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлэх, эсхүл стандарт, заавар, кодекс зэрэг байдлаар зохицуулах
2	Зорилго	Зохицуулах, хяналт тавих зорилго	Барууны улсуудад бизнесийн зорилгоор ашигладаг	Журмыг шинэчлэх тохиолдолд зорилгыг тодорхойлох
3	Журмын үйлчлэх хүрээ	ТЭЗҮ-ийн журамд 4 бичиг баримт зохицуулахаар заасан.	ТЭЗҮ-ийн журмын сүүлийн 2 бүлэг зөвхөн ТЭЗҮ-тэй хамааралтай	Эдгээр бичиг баримтад процедурын зохицуулалт хийх эсэхийг тодорхойлох
4	ТЭЗҮ боловсруулагчийн тусгай зөвшөөрөл	БХБЯ-аас гаргасан журам	МБҮА ТББ-аас тусгай зөвшөөрлийг олгодог боловч журам хүчин төгөлдөр бус болсон.	Эрх олгох байгууллагыг тодорхой болгох, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.
5	Давхцал, зөрчил	ТЭЗҮ-ийн журам, Зөвлөлийн дүрэм	Шинжээч болон ТЭЗҮ хүлээж авах зэрэгтэй холбоотой заалтууд давхцсан, зөрчилтэй.	ТЭЗҮ-ийн журмыг Зөвлөлийн дүрэмд нийцүүлэн засах, эсхүл Зөвлөлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

6	Үйлчлэхгүй байх тохиолдолд, нарийвчлал	Төслийн онцлогоос шалтгаалахгүйгээр адил шаардлагууд тавигдсан	Уян хатан үйлчилж болох эсэх талаарх зохицуулалт байхгүй ба нарийвчлалын талаар шаардлага тавигдаагүй	Тодорхой зохицуулалт оруулж өгөх
7	Байгууллага, хэлтсийг дурдах	Журамд (ii) Ашигт малтмалын газрын Геологи судалгааны хэлтсийн архив болон (iii) Уул уурхай, судалгааны хэлтэс, нүүрсний төсөл бол Нүүрс, судалгааны хэлтэст хүлээлгэн өгөх тухай зохицуулалт тусгагдсан	Байгууллага, хэлтсийн албан ёсны нэр өөрчлөгдсөн	Чиг үүргийг нь тусгаж байгууллагыг дурдах
8	Хуулийн зохицуулалтаас давсан үүрэг	ТЭЗҮ-ийн журамд тусгай зөвшөөрөл эзэмшигч ТЭЗҮ-ийг шинэчлэх үүргийг тусгасан	Журам нь хуульд зааснаас давсан үүрэг оногдуулахгүй байх	Шинэчлэх, өөрчлөхтэй холбоотой заалтыг засах
9	Нууцлал	Ашигт малтмалын тухай хууль, ТЭЗҮ-ийн журам ба Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам	Байгаль орчны нөлөөлөлтэй холбоотой мэдээллийг нууцад хамааруулахыг хориглоно	Байгаль орчин, ашигт малтмалын чиглэлийн 30 хуулийн хийдэл, зөрчил, давхардлыг тогтоох, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах судалгааны ажлын тайланд дурдсаныг харгалзах

10	Хугацаа	Ашигт малтмалын тухай хууль, ТЭЗҮ-ийн журам ба Зөвлөлийн дүрэм	Процедурын шинжтэй зохицуулалтыг тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томьёолсон байх	ТЭЗҮ-ийг хүргүүлэх, хянах, хүлээн авах хугацааг бодитоор тодорхойлох
----	---------	--	--	--